

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 05 өдөр

Дугаар

А/Б

Чөлөө

2021 оны эхний хагас жилийн үр дүнгийн
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2, 1.2.2, 2.1, 2.2, 2.3, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч Л.Одонтуяа нь 2021 оны эхний хагас жилийн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргээ амжилттай сайн биелүүлж, хангалттай үнэлгээ авсан тул үндсэн цалингаас 80 хувиар тооцон үр дүнгийн урамшуулал 739565 /долоон зуун гучин есөн мянга таван зуун жаран тав/ төгрөгийг олгосугай.
2. Дотоод аудитор Э.Цэлмэгбаяр нь 2021 оны эхний хагас жилийн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргээ амжилттай сайн биелүүлж, хангалттай үнэлгээ авсан тул үндсэн цалингаас 80 хувиар тооцон үр дүнгийн урамшуулал 585222 /таван зуун наян таван мянга хоёр зуун хорин хоёр/ төгрөгийг олгосугай.
3. Үр дүнгийн урамшуулалд зарцуулагдах 1324787 /нэг сая гурван зуун хорин дөрвөн мянга долоон зуун наян долоо/ төгрөгийг батлагдсан төсөв багтаан үндсэн цалин зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Одонтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Н.АЛТАНЦЭЦЭГ

4201210077